



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/570

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 11 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн тооцсугай.

3. Нийслэлийн Наркологийн төв эмнэлгийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг үндэслэн 62/2021 дугаартай Магадлан итгэмжлэлийн батламжийг Нийслэлийн Аддиктологийн төв нэртэйгээр өмнөх батламжийн хугацаагаар дахин шинээр олгосугай.

4. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222790

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 30 - ны өдрийн дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэг дсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Сонгинохайрхан дүүрэг, Энх-Ачит өрхийн эрүүл мэндийн төв	395/2022	2 жил	2022.12.11	2024.12.11
2.	Сонгинохайрхан дүүрэг, Гурван цүүр өрхийн эрүүл мэндийн төв	396/2022	2 жил	2022.12.11	2024.12.11
3.	Сонгинохайрхан дүүрэг, Батцэцэн өрхийн эрүүл мэндийн төв	397/2022	2 жил	2022.12.11	2024.12.11
4.	Сонгинохайрхан дүүрэг, Санхум өрхийн эрүүл мэндийн төв	398/2022	2 жил	2022.12.11	2024.12.11
5.	Сонгинохайрхан дүүрэг, Отгон долоон бурхан өрхийн эрүүл мэндийн төв	399/2022	2 жил	2022.12.11	2024.12.11
6.	Сонгинохайрхан дүүрэг, Эхэн босго өрхийн эрүүл мэндийн төв	400/2022	3 жил	2022.12.31	2025.12.31
7.	Хан-Уул дүүрэг, ОБЕГ-ын харъяа Давтан сургалт, сэргээн заслын төв 113-р анги Жаргалант сувилал	401/2022	2 жил	2022.12.04	2024.12.04
8.	Баян-Өлгий аймаг, Сансар эмнэлэг	402/2022	3 жил	2022.11.30	2025.11.30
9.	Орхон аймаг, Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв	403/2022	3 жил	2022.12.04	2025.12.04
10.	Орхон аймаг, Баян-Өндөр Мед ХХК-ийн Баян-Өндөр Мед нэгдсэн эмнэлэг	404/2022	3 жил	2022.12.11	2025.12.11
11.	Өвөрхангай аймаг, Есөнзүйл сумын эрүүл мэндийн төв	405/2022	3 жил	2022.12.23	2025.12.23
12.	Өвөрхангай аймаг, Өлзийт сумын эрүүл мэндийн төв	406/2022	3 жил	2022.12.23	2025.12.23
13.	Өвөрхангай аймаг, Сант сумын эрүүл мэндийн төв	407/2022	2 жил	2022.12.24	2024.12.24
14.	Увс аймаг, Увс-Мөнхтэнгэр ХХК-ны Жаргалан эмнэлэг	408/2022	2 жил	2022.12.01	2024.12.01
15.	Ховд аймаг, Дөргөн сумын эрүүл мэндийн төв	409/2022	2 жил	2022.12.01	2024.12.01
16.	Ховд аймаг, Манхан сумын эрүүл мэндийн төв	410/2022	3 жил	2022.12.01	2025.12.01
17.	Ховд аймаг, Ачлалнаран хайрхан ХХК-ийн Ивээл эмнэлэг	411/2022	3 жил	2022.12.02	2025.12.02